



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/23

Баян-Өндөр сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын "Тэмдэглэлт өдөр зохион байгуулах тухай" 2025 оны А/85 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн "Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай" 02/16 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Аймгийн 2026 оны төсөв батлах тухай" 02/58 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны А/116 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дэлхийн эмч нарын өдөр"-ийг тохиолдуулан хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд үр бүтээл, амжилт гаргасан шилдэг эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тодруулан алдаршуулах, мэргэжлийн үнэ цэнийг өсгөх, оношилгоо эмчилгээнд нэвтрүүлсэн шилдэг арга туршлагыг олон нийтэд сурталчлах, эрүүл мэндийн ажилтны хөгжлийг дэмжих, тэдний бүтээлч сэтгэлгээ, мэргэжлийн ур чадвар, нотолгоонд суурилсан судалгаа шинжилгээг хөгжүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн салбарын тэмдэглэлт өдрийг угтсан олон талт арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн салбарын тэмдэглэлт өдрүүдэд олон талт арга хэмжээг удирдамжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч, Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн (П.Хишгээ)-д үүрэг болгосугай.

3. Тус арга хэмжээг зохион байгуулахад идэвх санаачилгатай оролцож, хамтран ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

4. Шаардагдах 8.500.000 (Найман сая таван зуун мянга)-н төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан) -д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны  
03 сарын 16-ний өдрийн 162-т тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт



**“ДЭЛХИЙН ЭМЧ НАРЫН ӨДӨР”-ИЙГ ТОХИОЛДУУЛАН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРИЙГ УГТСАН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

**ЗОРИЛГО:** Дэлхийн эмч нарын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд аймгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлст үр бүтээлтэй, амжилт гарган ажиллаж буй эмч нарын хөдөлмөрийг үнэлэх, эмч мэргэжлээрээ бахархах, мэргэжлийн үнэ цэнэ, нэр хүндийг өргөх, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх

**ЗОРИЛТ :**

1. Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх, эмч нарын дундахь эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

2. Эмч нарын мэргэжлээрээ бахархах, ажлын онцлог, ололт амжилтыг олон нийтэд сурталчлан таниулах, ур чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах

**ХУГАЦАА:** 2026 оны 03 сарын 05-наас 2025 оны 3 сарын 31-ны өдөр хүртэл

**ХАМРАХ ХҮРЭЭ:** Эрүүл мэндийн газар, сум болон өрхийн эрүүл мэндийн төвүүд, Хойд бүсийн Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт сувиллын цогцолбор, Баян-Өндөрмед нэгдсэн эмнэлэг, Хувийн хэвшлийн ор бүхий клиник, оргүй клиникууд, Шүдний мэргэжилтний холбоо, Эм холбоо, Хүчний байгууллага, аж ахуйн нэгж байгууллага

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР:**

№	Үйл ажиллагаа	Хаана, хэзээ	Хариуцах мэргэжилтэн, албан байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	“Эмч тандаа талархъя” аяныг зохион байгуулах	2026 оны 3 дугаар сарын 5-наас 3 сарын 30-ны өдөр хүртэл	ЭМГ НЭМТ Ажлын хэсэг	ЭМБ –ууд
2	Эмч нарын дунд эмнэлзүйн ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалт зохион	2026 оны 3 дугаар сарын 16-аас 3 сарын 26-ны өдөр	ЭМГ-ын дэргэдэх ЭМЁССХороо ХШХ ХБХОЭДТ	ЭМБ –ууд
3	Эрдэм шинжилгээ онол практикийн хурал зохион	2026 оны 3 дугаар сарын 24 -ны өдөр	ЭМГ БОЭТ	ЭМБ-ууд

	байгуулах	Амарын танхим	ХБХОЭДТ ӨАУХолбоо	
4	“Эрдэнийн чагнуур” шилдэг эмч шагналын материал хүлээн авах, шалгаруулах ажлын хэсгийг хуралдуулах	2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл ЭМГ-ын №1 тоот өрөө	ЭМГ Ажлын хэсэг	ЭМБ-ууд
5	Спортын арга хэмжээ зохион байгуулах	2026 оны 3 дугаар сарын 27, 28-ны өдөр	ЭМГ ХХ-ын Чандмань эрдэнэ холбоо Ажлын хэсэг	ЭМБ-ууд
6	Шагнал гардуулах Хүндэтгэлийн ажиллагааг үйл зохион байгуулах	2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 10.00 цагт ЗДТГ-ын Хүндэтгэлийн өргөө	ЭМГ УТХ Ажлын хэсэг	ЭМБ-ууд
7	“Өнөөдөр Дэлхийн эмч нарын эдөр” хүндэтгэлийн арга хэмжээ	Тессоро 2026 оны 3-р сарын 30-ний 18.00 цагт	Ажлын хэсэг ХХ-ын Чандмань эрдэнэ холбоо ХБХОЭДТ ӨАУХолбоо	ЭМБ-ууд
8	Эмч нарын эрүүл мэндийг дэмжих урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах, эрүүлжүүлэх арга хэмжээг өрнүүлэх, нэгдсэн судалгаа гаргах, үр дүнг тооцох	2026 оны 3 сарын 15-наас 2026 оны 4 сарын 18 хүртэл	ЭМГ ХБХОЭДТөв БОЭТ	ЭМБ-ууд

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
03 сарын 24 -ний өдрийн А/23 тоот  
тушаалын хоёрдугаар хавсралт



**“ДЭЛХИЙН ЭМЧ НАРЫН ӨДӨР”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

**АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ :** П.Хишгээ /Эмнэлгийн тусламж чанар, магадлан  
итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн/

**НАРИЙН БИЧИГ:** Б.Ариунжаргал /ЭМГ-ын Салбарын хүний нөөцийн  
төлөвлөлт хангалт, сургалт, нийгмийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн/

**ГИШҮҮД:** О.Гантулга / Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн  
Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /

Р.Мөнхбат/ Хойд бүсийн Хавдрын оншилгоо эмчилгээний  
дэд төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал/

Г.Эрдэнэтуяа/Өрхийн анагаах ухааны холбооны тэргүүн/

Д.Эрдэнэчимэг /Эрдэнэт цогцолбор сувиллын Эмчилгээ  
эрхэлсэн орлогч дарга/

Д. Оюунцэцэг /Хувийн хэвшлийн Чандмань эрдэнэ холбооны  
тэргүүн/

М.Отгонжаргал /Мишээл клиникийн захирал /

Д.Мөнгөн-эрдэнэ /Шүдний мэргэжилтний холбооны тэргүүн/

М.Аззаяа /Эм холбооны тэргүүн/

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
03 сарын 22 -ний өдрийн 4128-тоот  
тушаалын гуравдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДЭД ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ /төг/	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	
1.1	“Эрдэнийн чагнуур”- Шилдэг эмчийн шагнал	Цом	1	500.000	500.000	ЭМГ	ЭМБ-ууд
		Урамшуулал	1	1.000.000	1.000.000		
		<b>Нийт 1.500.000</b>					
1.2	Спортын арга хэмжээ	Медаль	32	15000	480.000	ЭМГ	ХХЭМБ -Чандмань эрдэнэ холбоо
		Өргөмжлөл	12	15000	180.000		
		Шүүгчийн хөлс	4	100000	400.000		
		Шүүгчийн хоолны зардал	4	50000	200.000		
		Заалны түрээс	2	500000	1.000.000		
<b>Нийт 2.260.000</b>							
1.2	“Өнөөдөр Дэлхийн эмч нарын өдөр” хүндэтгэлийн арга хэмжээ /шагнал, цэнгүүн/	Морин хуур урлагийн тоглолт	2	270000	540.000	ЭМГ	ЭМБ-ууд Ажлын хэсэг
		Хөтлөгчийн зардал	1	500000	500.000		
		Амьд хөгжим, урлагийн тоглолт	4	1700000	1.700.000		
<b>Нийт 2.740.000</b>							
1.3	Ёс зүй, харилцаа хандлагын төвийн сургалт зохион байгуулах	Сургагч багшийн замын зардал	2	50000х2 удаа	200.000	ЭМГ	ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороо
		Буудлын зардал	2	100.000	200.000		
		Сургагч багшийн ажлын хөлс	2	200.000	400.000		
		Оролцогчдын цайны зардал	120	5000х2у даа	1.200.000		
<b>Нийт 2.000.000</b>							
<b>Нийт дүн</b>						<b>8.500.000</b>	